



ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн "Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай" А/39, А/12 дугаар хамтарсан тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1."Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ, хугацаанд өөрчлөлт орсон иргэдэд тахир дутуугийн тэтгэвэр тогтооход баримтлах заавар"-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү зааврыг 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг аймаг (дүүрэг)-ийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Аймаг (дүүрэг)-ийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг), Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс (П.Мөнхтулга)-т даалгасугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (Г.Саран)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЗОРИГТ

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын
ерөнхий газрын даргын 2017 оны
02 дугаар сарын 08-ны өдрийн
А/15 тоот тушаалын хавсралт

ДААТГУУЛАГЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫН
ХУВЬ ХЭМЖЭЭ, ХУГАЦААНД ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ИРГЭДЭД ТАХИР
ДУТУУГИЙН ТЭТГЭВЭР ТОГТООХОД БАРИМТЛАХ ЗААВАР

Нэг. Зорилго

1.1. Энэхүү зааврыг Эрүүл мэнд, спортын сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны "Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай" А/252, А/74 дүгээр хамтарсан тушаал (цаашид "2016 оны жагсаалт" гэх)-аар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнд нь өөрчлөлт орсон болон хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ нь цуцлагдсан иргэд, даатгуулагчдаас гаргасан өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэх, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн "Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай" А/39, А/12 дугаар хамтарсан тушаал (цаашид "2017 оны жагсаалт" гэх)-ын хэрэгжилтийг зохион байгуулахад баримтална.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаанд нь өөрчлөлт орсон даатгуулагчийн тахир дутуугийн тэтгэврийг шинэчлэн тогтооходоо Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон энэ зааврыг мөрдлөг болгоно.

2.2. 2016 оны жагсаалт мөрдсөнөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнд нь өөрчлөлт орсон болон цуцлагдсан иргэд хамаарна.

Гурав. Үндсэн хэсэг

Энэхүү зааврыг аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсүүд дор дурдсанаар хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1. 2016 оны жагсаалтаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь нь нэмэгдсэн боловч тэтгэврийн хэмжээ нь буурсан иргэдийн тэтгэврийг урд авч байсан тэтгэврийн хэмжээгээр нь тооцон олгох;

3.2. 2016 оны жагсаалтаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ нь буурсаны улмаас тэтгэврийн хэмжээ нь буурсан иргэдийн тэтгэврийг 2016 оны жагсаалтаас өмнө авч байсан тэтгэврийн хэмжээгээр тооцон 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгох;

3.3. Дахин магадлалд орж хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ шинээр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг тогтооход тэтгэвэр нь 2017 оны жагсаалтаас өмнө авч байсан тэтгэврийн хэмжээнээс буурахаар бол өмнө нь авч байсан тэтгэврийн хэмжээгээр тооцон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр гарсан өдрөөс эхлэн тэтгэврийг нь үргэлжлүүлэн олгох;

3.4. 2016 оны жагсаалтын дагуу хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ нь цуцлагдсан иргэд 6 сарын дотор хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ тогтоолгосон бол тухайн иргэний тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т заасны дагуу тогтоож, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр гарсан өдрөөс эхлэн олгох, 6 сараас дээш хугацааны дараа хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ тогтоолгосон бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тэтгэврийг нь шинээр тогтоож олгох;

3.5. 2016 оны жагсаалтын дагуу тахир дутуугийн бүрэн тэтгэвэр авч байгаад хөдөлмөрийн чадвар алдалт нь цуцлагдсан иргэд дахин магадлалд орсноор тахир дутуугийн бүрэн тэтгэвэр авах болзлыг хангахгүй тохиолдолд тэтгэврийг нь 2017 оны жагсаалт батлагдахаас өмнө авч байсан тэтгэврийн хэмжээгээр тооцож үргэлжлүүлэн олгох;

3.6. 2016 оны жагсаалтаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ нь цуцлагдсан иргэд 2017 оны жагсаалтын дагуу дахин магадлалд орж хөдөлмөрийн чадвар алдалтын акт тогтоогдсон иргэдийн тэтгэврийг шинэчлэн тогтоож Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр гарсан өдрөөс эхлэн тэтгэврийг нь олгох;

3.7. Нийгмийн даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгон авч байгаад 2016 оны жагсаалтаар хөдөлмөрийн чадвар алдалт нь цуцлагдсан иргэд дахин магадлалд орсон тохиолдолд тэтгэврийг нь шинээр тогтоож олгох;

3.8. Нийгмийн халамжийн сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 2016 оны жагсаалтаар хөдөлмөрийн чадвар алдалт нь цуцлагдаад 2017 оны жагсаалтын дагуу дахин магадлалд орох хүртэл хугацаанд сайн дурын даатгалд хамрагдаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаагаар тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгохоор бол Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг үндэслэн тахир дутуугийн тэтгэврийг тогтоох зэрэг болно.

Дөрөв. Хариуцлага

4.1. Энэхүү заавар болон Нийгмийн даатгалын хуулиудыг зөрчиж хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй нийгмийн даатгалын байцаагчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

